



УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 1420

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.1, 8.1.3, 9.1.2 дахь заалт, Иргэний бүртгэлийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Улсын их хурлын 2009 оны "Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах тухай" 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах журам"-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг аймаг, дүүргийн бүртгэлийн хэлтсийн дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн технологийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Алтанзүрх, Иргэний бүртгэлийн газрын дарга Ц.Батцайз, нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2010 оны 315 дугаар тушаалаар баталсан "Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.



00002437

ИРГЭНИЙ ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛ
ЯВУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь иргэний шинэчилсэн бүртгэл/цаашид Шинэчилсэн бүртгэл гэх/ явуулах ажиллагааг зохион байгуулах, иргэнийг шинэчилсэн бүртгэлд бүртгэх, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэх, тэдгээрт хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Монгол Улсын харьяат иргэн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5.3.1, 5.3.9, 5.3.12-т заасан төрсний, иргэний үнэмлэхийн, иргэний байнгын оршин суугаа газрын бүртгэлийг баталгаажуулах, 5.1.11-д заасан биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийг (гарын хурууны хээ) шинээр бүртгэнэ.

1.3. Хилийн чанадад амьдарч буй Монгол Улсын харьяат иргэнийг шинэчилсэн бүртгэлд бүртгэх асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан журмаар зохицуулна.

1.4. Монгол Улсын иргэнийг шинэчилсэн бүртгэлд улсын бүртгэгч бүртгэнэ.

ХОЁР. Иргэнийг шинэчилсэн бүртгэлд
бүртгэх зарчим

2.1. Иргэнийг шинэчилсэн бүртгэлд бүртгэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.1.1. Иргэний шинэчилсэн бүртгэл нь иргэний улсын бүртгэлийн нэгдсэн сан дахь мэдээлэлд үндэслэсэн байх;

2.1.2. Иргэний баримт бичиг зөрчилгүй байх;

2.1.3. 16-аас дээш насны иргэний биечлэн бүртгэх;

2.1.4. 16-аас доош насны иргэний хувьд түүний эх, эцэг, асран хамгаалагч, харгалzan дэмжигч нь бүртгүүлэх;

2.1.5. Иргэний үнэмлэхийн 25 болон 45 насны хугацаа сунгальт хийлгэхэд иргэн өөрийн биеэр ирэх;

ГУРАВ. Иргэний шинэчилсэн бүртгэлд
бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

3.1. Иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

3.1.1. Иргэний үнэмлэх /иргэний паспорт /

3.1.2. Төрсний гэрчилгээ /1951 оноос хойш төрсөн иргэн/;

3.1.3. Гэр бүлийн тухай хуулийн 66.1-д заасны дагуу асран хамгаалагч, харгалzan дэмжигчээр тогтоогдсон бол шүүхийн шийдвэр, сум, дүүргийн Засаг даргын захирамж, түүний хуулбар;

3.1.4. Хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад амьдарч байгаа бол тухайн байгууллагын тодорхойлолт;

ДӨРӨВ. Иргэний шинэчилсэн бүртгэлд
бүртгэх ажиллагаа

4.1. Улсын бүртгэгч энэхүү журмын 3.1-д заасан баримт бичгийг үндэслэн бүртгэлийн ажиллагааг явуулна. Үүнд:

4.1.1. Иргэний регистрийн дугаараар иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хайлт хийнэ;

4.1.2. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягтын програмын төлөв дээр иргэний овог, эцэг (эх)-ийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, иргэний үнэмлэхийн дугаар харагдана. Эдгээр мэдээллийг иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний мэдээлэлтэй тулгаж, шалгана;

4.1.3. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягтын шинээр оруулах мэдээллийг асуулгын дагуу бүртгэнэ;

4.1.4. Иргэний цээж зураг, биеийн давхцахгүй өгөгдлийг (гарын 10 хурууны хээ) зориулалтын төхөөрөмжөөр зааврын дагуу авч, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн мэдээллийн санд хадгална.

4.1.5. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн мэдээллийн сангаас (ИУБ-31) маягтыг хэвлэн, иргэнээр шинэчилсэн бүртгэлд үнэн зөв бүртгүүлснийг нотлуулж, гарын үсэг зуруулна;

4.1.6 Шинэчилсэн бүртгэлд бүртгүүлснийг нотлох (ИУБ-31) маягтын тасалбарыг иргэнд олгоно.

4.1.7. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн мэдээлэл иргэний баримт, бичиг дэх мэдээлэлтэй зөрүүтэй тохиолдолд төрсний, үрчилсний овог, эцэг (эх)-ийн нэр, нэр өөрчилсний гэрчилгээ болон иргэний үнэмлэхийг үндэслэн шинэчилсэн бүртгэлд бүртгэнэ.

**ТАВ. Улсын бүртгэгч шинэчилсэн бүртгэлийн
хадгаламжийн нэгж үүсгэх**

5.1. Шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн 20 иргэн тутамд нэрийн жагсаалтыг 2 хувь хэвлэн улсын бүртгэгч тэмдэг дарж, гарын үсэг зурж баталгаажуулан, жагсаалтыг 250 хүртэл хуудсаар дэвтэрлэж, архивын хадгаламжийн нэгж үүсгэнэ.

5.2. Шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэний цахим мэдээллийг зөөврийн хадгалах хэрэгсэлд хуулж, бичлэг хийсэн он, сар, өдөр, аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг бичиж товъёогжуулна.

5.3. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягтыг гэмтээсэн, хүчингүй болгосон тохиолдолд маягт бүрийн (А) талд тайлбар хийж, бүртгэлийн хяналтын улсын байцаагчид актаар шилжүүлнэ.

**ЗУРГАА. Шинэчилсэн бүртгэлийн хадгаламжийн
нэгжийг бүртгэлийн байгууллагад хүргүүлэх**

6.1. Иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэсэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягт, нэрийн жагсаалт, цахим мэдээлэл бүхий зөөврийн хадгалах хэрэгслийг сумын улсын бүртгэгч аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 7 хоногийн дотор хүргүүлнэ.

6.2. Энэхүү журмын 5.1 дэх хэсэгт заасны дагуу үүсгэсэн архивын хадгаламжийн нэгжийн 1 хувийг бүртгэл хийгдсэн суманд үлдээж, 1 хувийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлнэ.

6.3. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сумын улсын бүртгэгчийн ирүүлсэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягтыг цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, "Б" талыг тухайн хэлтсийн иргэний баримтын архивт үлдээн, "А" талыг 14 хоногийн дотор нэрийн жагсаалтаар Иргэний бүртгэлийн газарт, тухайн сарын цахим мэдээлэл бүхий зөөврийн хадгалах хэрэгслийг Мэдээллийн технологийн газарт дараа сарын 5-ны өдрийн дотор тус тус хүргүүлнэ.

6.4. Дүүргийн бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн тасаг нь шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягтыг цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, "Б" талыг Нийслэлийн улсын бүртгэлийн газарт, "А" талыг 7 хоногийн дотор Иргэний бүртгэлийн газарт, тухайн сарын цахим мэдээлэл бүхий зөөврийн хадгалах хэрэгслийг Мэдээллийн технологийн газарт дараа сарын 5-ны өдрийн дотор тус тус хүргүүлнэ.

6.5. Иргэний бүртгэлийн газар нь биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягтыг баталгаажуулан дугаар олгож, цагаан толгойн үсгийн дарааллаар ялгаж, иргэний баримтын архивт 7 хоногийн дотор хүргүүлнэ.

ДОЛОО. Шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг биеийн давхцахгүй өгөгдлийн мэдээллийн санд оруулах, шалгах

7.1. Аймаг, дүүргийн бүртгэлийн хэлтэст шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн мэдээллийг бүртгүүлсэн өдөрт нь, суманд шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн мэдээллийг аймгийн улсын бүртгэлийн хэлтэс хүлээн авсан өдөртөө багтаан мэдээллийн нэгдсэн санд оруулна.

7.2. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн ИУБ-31 маягтыг мэдээллийн санд шалгаж зөрчилтэй маягтыг харьяа хэлтэс, тасагт буцаан хүргүүлж зөрчлийг арилгуулна.

7.3. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн мэдээллийн сан болон иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл давхардаагүй, мэдээлэл зөрчилгүй иргэнд иргэний бүртгэлийн дугаар олгогдоно.

7.4. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл нь зөрсөн, давхардсан иргэний мэдээллийг Бүртгэлийн хяналтын хэлтэст шилжүүлнэ.

НАЙМ. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн маягтыг хүлээн авах

8.1. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягтыг нэрийн жагсаалтын дагуу Улсын бүртгэлийн еренхий газрын Иргэний баримтын архив хүлээн авна.

8.2. Иргэний бүртгэлийн дугаар олгогдсон иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн (ИУБ-31) маягтыг Иргэний баримтын архивын архивч баталгаажуулан иргэний хувийн хэрэгт байрлуулна.


8.3. Архивын эх нотлох баримттай зөрүүтэй, архиваас эх нотлох баримт нь одоогүй иргэний (ИУБ-31) маягтыг Бүртгэлийн хяналтын хэлтэст шилжүүлнэ.

ЕС. Иргэн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэнэйг мэдээлэх

9.1. Иргэн Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын цахим хуудас, улсын бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 утаснаас лавлах болон бусад хэлбэрээр холбогдож, аймаг, нийслэлд бүртгүүлсэн бол 5 хоног, суманд бүртгүүлсэн бол 10 хоногийн дараа шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн нь баталгаажсан эсэх мэдээллээ авна.

9.2. Шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, бүртгэлийн дугаар олгогдсон иргэний мэдээлэл, нэрийн жагсаалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн халамжийн үйлчилгээний асуудал эрхэлсэн байгууллага болон Улсын бүртгэлийн аймаг, нийслэл дүүрэг дэх нэгжид тус тус цахим хэлбэрээр 30 хоногийн дотор хүргүүлнэ.

АРАВ. Шинэчилсэн бүртгэлийн ажиллагаанд
хяналт тавих



10.1. Шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хяналтын улсын /ахлах/ байцаагч хэрэгжүүлнэ.

10.2. Шинэчилсэн бүртгэлийн ажиллагаанд дараах чиглэлээр хяналт тавьна. Үүнд:

10.2.1.Иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэх;

10.2.2.Улсын бүртгэгчийн бурдуулсэн шинэчилсэн бүртгэлийн хадгаламжийн нэгжид;

10.2.3.Иргэний шинэчилсэн бүртгэлийн материалыг бүртгэлийн байгууллагад хүргүүлэх;

10.2.4.Шинэчилсэн бүртгэлийн мэдээллийг цахим санд оруулах;

10.2.5.Биений давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн маягтыг архивын материалтай тулгах;

10.2.6.Биений давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн мэдээллийн санд иргэний мэдээллийг шалгах;

10.2.7.Иргэний шинэчилсэн бүртгэлийн ажиллагааны програм хангамж, сүлжээний аюулгүй байдал, нууцлал

10.2.8.Иргэний бүртгэлийн дугаар олголт;

10.3. Хяналтын улсын /ахлах/ байцаагч нь иргэний шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавихад "Улсын бүртгэл түүнтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам"-ыг мөрдөж ажиллана.

10.4. Шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагаа, улсын бүртгэгчийн сахилгын хэм хэмжээ, энэ журмын биелэлтэд тавих хяналтыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын бүх шатны удирдлага хэрэгжүүлнэ.

10.5. Шинэчилсэн бүртгэлд хяналт тавих ажиллагаанд тусгай техник, тоног төхөөрөмж ашиглаж болно.

АРВАН НЭГ. Бусад

11.1. Энэхүү журмын холбогдох заалтыг зөрчсөн буруутай албан хаагчид Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оо---